




ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2023



www.1212.mn



Дундговь аймаг
2024 он

Гарчиг

Оршил

Мал тооллогын товч түүх

Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт

1. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
2. Малтай өрх болон малчин өрх, малчдын тоо, тэдний ахуйн зарим үзүүлэлт
 - 2.1. Малтай өрх, малчин өрх
 - 2.2. Малтай өрхийн бүлэглэлт
 - 2.3. Малчдын мэдээлэл
 - 2.4. Малчдын нийгэм, соёлын зарим үзүүлэлт
3. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн
 - 3.1. Малын тоо, бүтэц
 - 3.2. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо
 - 3.3. Төл бойжилт
 - 3.4. Том малын зүй бус хорогдол
 - 3.5. Малын хээл хаялт, сувайралт
 - 3.6. Малын хэрэглээний зарлага
 - 3.7. Сүргийн бүтэц
 - 3.8. Тэжээвэр амьтад
4. Малжуулалт, шинээр гаргасан худгийн тайлан
 - 4.1. Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан
 - 4.2. Шинээр гаргасан, засварласан худгийн мэдээлэл
5. Газар тариалан
6. Улсын дүн бүхий хавсралт хүснэгт

Дүгнэлт

Мэдээллийн эх үүсвэр

Оршил

Дундговь аймгийн эдийн засгийн суурь голлох салбар бол хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуйн салбар юм.

Манай улс үндсэн хуулиндаа мал сүргийг үндэсний баялаг хэмээн зааж, мал тэжээвэр амьтдын тооллогыг жил бүр зохион байгуулан, үр дүнг үндэсний хэмжээнд тооцон бодлого төлөвлөлтөнд ашиглаж байна.

Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн 7-р зүйлийн 1 дэх заалтийн дагуу мал тэжээвэр амьтдын тооллогыг жил бүрийн 12 сарын 7-ноос 17-ны хооронд орон даяар зохион байгуулдаг.

Сүүлийн 5 жилийн мал, тэжээвэр амьтдын тооллогын онцлог нь малчдын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулдаг болсон юм. Энэ нь Монгол улсын төрөөс явуулж буй малчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр наашлуулах болон малчдыг нийгмийн даатгалд хамруулах бодлоготой уялдсан юм.

Энэхүү танилцуулгад 2023 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын дэлгэрэнгүй үр дүн болон газар тариалангийн салбарын тухайн оны төлөв байдлыг нэгтгэн тусгахыг зорьлоо. Манай аймгийн хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар нь газар зүйн байрлал, онцлог шинжээс шалтгаалан байгаль цаг уураас шууд хамааралтай бөгөөд мал аж ахуйн хувьд бэлчээрийн мал аж ахуй голлож байна.

Танилцуулгад малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, мал төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, хээл хаялт, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчин өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд зэрэг мал аж ахуй, хөдөө аж ахуйтай холбоотой бүхий л Статистик мэдээлэл, үзүүлэлтүүдийг хамрууллаа.

Ингэснээр манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, салбарын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төлөвлөхөд суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

МАЛ ТООЛЛОГЫН ТОВЧ ТҮҮХ

Мал аж ахуй нь Монгол орны хувьд амьжиргааны гол эх үүсвэр болсон анхдагч үйлдвэрлэлийн салбар байсны хувьд бүртгэл, статистикийн ажил ч энэ салбараас эхлэн хөгжсөн түүхтэй.

XIII зууны үед Монгол улсад хүн, малын тооллого явуулж байсан баримт түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Манжийн хараат байх үед Монголд мал тооллого явуулж байсан боловч нэгдсэн тооллого хийж чаддаггүй, орон нутгийн чанартай байв. Аймаг, хошуудад янз бүрийн хугацаанд, өөр өөрсдийн шаардлага үзэмжээр мал тооллого явуулж байсан байна.

Гадаад Монголын Засгийн газар 1918 онд хүн ам, малын тооллого явуулсан байна. Уг тооллого нь халхын 4 аймаг, лам, ноёд, шавь албат ардууд, сүм хийдийн малыг хамруулсан боловч Ховдын хязгаар, Дархадын хязгаар, Хөвсгөл нуур орчмын Богд гэгээний эзэмшил нутгийн мал ороогүй ажээ.

Ардын засгийн газар 1924 онд Дотоод яамны бүтцэд Тоо бүртгэлийн хэлтсийг шинээр байгуулж, мал тооллогыг үнэн зөв явуулах талаар онцгой анхаарч, тооллого явуулах, данс бүртгэлийг нэгтгэх, тушаах цаг хугацааг тогтоож, хуучин төлөөний түшмэл дээр боловсрол чадвартай тусгай түшмэлийг нэмэн томилж, ард олонд тайлбарлан таниулах ажлыг зохиосны үр дүнд анх удаа улсын хэмжээгээр хугацаа, аргачлалын хувьд нэгдсэн программтай мал тооллого явагдсан байдаг. Мал тооллогод урьд өмнө нь бүртгэгдэхгүй байсан цаа буга, илжиг, луус, өвс хадлан, тариалангийн талаар зарим нэмэлт үзүүлэлтийг 1924 оноос эхлэн оруулсан байна. Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байсан бол 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болсон. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлагын үзүүлэлт бүрэн гарч дууссан, малчид өвөлжөөндөө бууж, хүн, малын хөдөлгөөн харьцангуй бага байдаг зэрэг давуу талтай юм.

Малын хашаа байрын тооллогыг 1966 оноос, худаг, малын тэжээлийн тооллогыг 1972 оноос нэмж мал тооллоготой хамтруулан явуулдаг болов. Ардын хувийн аж ахуйтны малыг 1959-1960 онд нийгэмчилж, хоршоололд хамруулж дууссан бол 1992 онд малыг хувьчлах ажил хийгдэж дууссан билээ.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх.

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр -1 бод 6 хонь - 1 бод

1 тэмээ - 1.5 бод 8 ямаа - 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ- 5 хонь 1 хонь - 1 хонь

1 адуу - 7 хонь 1 ямаа - 0.9 хонь 1 үхэр- 6 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал, Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцуулсан үзүүлэлтийг оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан 100 -гаар үржүүлнэ.

Бойжилтийн хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур – 20-25 Бух – 35-45

Азарга- 12-15 Хуц, Ухна - 25-30

Малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бусын хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс - 0.45
Таримал тэжээл - 0.35
Даршны ургамал - 0.25
Гар тэжээл, хужир шүү - 1.0
Төмс ногооны хаягдал - 0.22
Үр тарианы хаягдал - 0.9
Лай - 0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

• Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. Шүүст тэжээл- Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
 - Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
 - Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно. /1тн=10 цн=1000кг /

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Эдийн засгийн бүсэд:

Баруун бүс - Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

Хангайн бүс - Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг

Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг

Зүүн бүс - Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг

Улаанбаатар бүс - Улаанбаатар хот

1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

1.1. Мал аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2023 оны урьдчилсан байдлаар 291.8 тэрбум төгрөг болж, аймгийн ДНБ-ий 56.0 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж өмнөх оноос 3.2 хувиар буурсан байна.

ЗУРАГ 1. ДНБ-Д ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



1.2. Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлт

2023 онд 15903.2 тн өвс хадлан, 2237.8 тн гар тэжээл, 1946.7 тн хужир шүү бэлтгэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 120.8 хувиар, хужир шүү 37.7 хувиар тус тус өсч, гар тэжээл 31.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 1. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2023/ 2022
Өвс, хадлан, тн	1,143.1	1,766.6	7,344.9	12,426.	4773.3	7202.4	15903.2	220.8
Гар тэжээл, тн	7,070.2	6,826.6	3,624.6	1,005.2	4153.1	3256.0	2237.8	68.7
Хужир, шүү, тн	2,055.5	2,394.6	2,338.5	107.5	2471.1	1413.7	1946.7	137.7
Тариалсан талбай, га	91.8	33.7	36.5	52.4	35.5	50.1	46.7	93.2
Хураан авсан ургац, тн	246.3	188.2	298.7	374.4	320.6	410.6	396.7	96.6



МАЛЧИН ӨРХ, АМ БҮЛ



МАЛЧДЫН АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ



2. МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХ, ТЭДНИЙ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

2.1 . Малчин өрх, малтай өрх


Дундговь аймагт 2023 оны жилийн эцэст нийт 14875 өрхийн 46131 хүн ам амьдарч байна. Өмнөх оноос 0.1 хувь ба 17 өрхөөр, 2.3 хувь буюу 1068 хүнээр буурсан.

Хүснэгт 2. Өрх, хүн ам тоо, байршлаар

Сумд	Өрх	Бүгд хүн ам	Эрэгтэй	Эмэгтэй	Хөдөөд
Адаацаг	753	2594	1340	1254	2176
Баянжаргалан	436	1246	671	575	729
Говь-Угтаал	470	1393	748	645	975
Гурвансайхан	680	2028	1042	986	1702
Дэлгэрхангай	681	2159	1126	1033	1305
Дэлгэрцогт	553	1499	800	699	1037
Дэрэн	638	2087	1064	1023	1627
Луус	593	1818	957	861	1176
Өлзийт	812	2207	1225	982	1857
Өндөршил	459	1414	700	714	1065
Сайнцагаан	5323	16866	8002	8864	3318
Сайхан-Овоо	670	2045	1073	972	1402
Хулд	758	2181	1142	1039	1438
Цагаандэлгэр	354	980	520	460	494
Эрдэнэдалай	1695	5614	2834	2780	4512
Дүн	14875	46131	23244	22887	24813

2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 8821 малтай өрх тоологдсон ба үүнээс 7347 өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна. Малчин өрхийг сумдаар авч үзвэл Эрдэнэдалай суманд 186 өрх, Өлзийт суманд 29 өрх, Дэлгэрцогт суманд 28 өрх, бусад сумдад 1-16 өрхөөр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг. 2. Малчин өрх, малчдын тоо, 2023 оны жилийн эцэст



Аймгийн нийт өрхийн 49.4 хувийг малчин өрх эзэлж байна. Малтай болон малчин өрхийн тоог өмнөх онтой харьцуулахад малтай өрх 1.2 хувиар, малчин өрх 4.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Малчин өрх, малтай өрхийн тоо, жил бүрийн эцэст

Сумдын нэр	Малтай өрхийн тоо					Малчин өрхийн тоо				
	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН
ДҮН	8593	8967	8942	8930	8821	7248	7596	7670	7682	7347
Сайнцагаан	1016	1084	1084	1120	1090	831	883	893	928	912
Адаацаг	643	659	658	653	648	539	556	554	549	544
Баянжаргалан	295	300	295	284	282	234	249	255	249	240
Говь-Угтаал	357	369	371	368	371	279	282	283	289	287
Гурвансайхан	536	560	558	568	567	495	508	507	519	512
Дэлгэрхангай	582	611	594	581	573	406	453	452	433	428
Дэлгэрцогт	435	444	441	426	416	384	390	391	375	347
Дэрэн	497	512	521	533	541	428	445	453	466	455
Луус	418	447	453	450	440	362	363	392	398	383
Өлзийт	654	700	706	713	699	585	635	646	644	615
Өндөршил	360	376	371	357	354	269	292	292	294	285
Сайхан-Овоо	509	518	516	520	521	402	410	437	430	428
Хулд	582	601	614	624	611	477	512	517	539	529
Цагаандэлгэр	315	324	315	314	311	273	272	270	261	260
Эрдэнэдалай	1394	1462	1445	1419	1397	1284	1346	1328	1308	1122

2.2. Малтай өрхийн малын бүлэглэлт


2023 оны иргэдийн малын бүлэглэлтээс авч үзвэл нийт малчин өрхийн 11.5 хувь нь 100 хүртэл малтай, 16.1 хувь нь 101-200 малтай, 36.0 хувь нь 201-500 малтай, 25.1 хувь нь 501-999 малтай, 11.3 хувь нь 1000-аас дээш малтай байна.

Хүснэгт.4. Малчин өрхийн бүлэглэлт

Бүлэглэлт	Малчин өрх					Дүнд эзлэх хувь				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
ДҮН	7248	7598	7670	7682	7347	100	100	100	100	100
30 хүртэл малтай	114	175	262	188	162	1.6	2.3	3.4	2.45	2.2
31-50	142	200	290	239	203	2	2.6	3.8	3.11	2.8
51-100	386	524	695	574	477	5.3	6.9	9.1	7.47	6.5
101-200	949	1216	1505	1337	1184	13.1	16	19.6	17.40	16.1
201-500	2628	2778	2812	2738	2647	36.3	36.6	36.7	35.64	36.0
501-999	2032	1874	1484	1813	1845	28	24.6	19.3	23.60	25.1
1000-1499	745	666	523	640	693	10.3	8.8	6.8	8.33	9.4
1500-2000	176	115	75	119	103	2.4	1.5	1	1.55	1.4
2001-ээс дээш	76	50	24	34	33	1	0.7	0.3	0.44	0.5

Иргэдийн малын тооны бүлэглэлтээс харвал нийт өрхөд эзлэх тухайн бүлгийн хувь өмнөх оноос 30 хүртэл малтай малчин өрх 0.25 хувиар, 31-50 хүртэл малтай малчин өрх 0.3 хувиар, 51-100 малтай малчин өрх 0.97 хувиар, 101-200 хүртэл малтай малчин өрх 1.3 хувиар, 1500-2000 малтай малчин өрх 0.15 хувиар тус тус буурч, 201-500 малтай малчин өрх 0.36 хувиар, 501-999 малтай малчин өрх 0.36 хувиар, 1000-1499 малтай малчин өрх 1.07 хувиар, 2001-ээс дээш малтай малчин өрхийн эзлэх хувь 0.06 хувиар тус тус өссөн байна. Энэ жилийн хувьд малын тоо толгой өсч, үүнтэй холбоотой 201-500 малтай малчин өрх, 1000-1499 малтай малчин өрх, 2001-с дээш малтай малчин өрхийн тоо тус тус өссөн байна.

Зураг 3. Малтай өрхийн бүлэглэлт



Хүснэгт.5. Малчин өрхийн бүлэглэлт, сумаар, 2023 оны жилийн эцсийн байдлаар

Сумд	Малчин өрхийн бүлэглэлт									
	Бүгд	30 хүртэл малтай	31-50 малтай	51-100 малтай	101-200 малтай	201-500 малтай	501-999 малтай	1000-1499 малтай	1500-2000 малтай	2001-аас дээш малтай
Сайнцагаан	912	20	32	85	183	353	184	41	10	4
Адаацаг	544	3	8	30	84	215	119	76	7	2
Баянжаргалан	240	4	8	23	37	62	63	35	7	1
Говь-Угтаал	287	6	9	17	31	75	93	41	12	3
Гурвансайхан	512	21	14	35	77	161	142	56	6	0
Дэлгэрхангай	428	9	20	32	76	189	79	17	6	0
Дэлгэрцогт	347	8	6	21	69	114	80	33	7	9
Дэрэн	455	11	9	25	54	152	131	54	13	6
Луус	383	3	8	18	61	147	109	34	3	0
Өлзийт	615	13	21	51	91	185	184	63	6	1
Өндөршил	285	8	7	16	40	97	70	41	6	0
Сайхановоо	428	7	10	14	79	177	114	25	1	1
Хулд	529	7	7	19	88	197	163	43	4	1
Цагаандэлгэр	260	5	4	16	45	90	60	35	4	1
Эрдэнэдалай	1122	37	40	75	169	433	254	99	11	4
Нийт	7347	162	203	477	1184	2647	1845	693	103	33

2023 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойн тоогоор/ 471 мал байгаа нь өмнөх оноос 20 толгой малаар өссөн үзүүлэлт байна.

Хүснэгт 6. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлт жил бүрийн эцэст

Бүлэглэлт	Малтай өрхийн тоо					Нийт дүнд эзлэх хувь				
	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН
Бүгд	8593	8967	8942	8930	8821	100	100	100	100.0	100
10 хүртэлх	40	55	91	60	62	0.5	0.6	1.0	0.7	0.7
11-30	206	301	426	322	331	2.4	3.4	4.8	3.6	3.8
31-50	297	373	496	404	386	3.5	4.2	5.5	4.5	4.4
51-100	691	866	1001	904	857	8	9.7	11.2	10.1	9.7
101-200	1350	1620	1818	1664	1563	15.7	18.1	20.3	18.6	17.7
201-500	2933	3021	2983	2950	2923	34.1	33.7	33.4	33.0	33.1
501-999	2076	1898	1503	1830	1869	24.2	21.2	16.8	20.5	21.2
1000-1499	748	668	523	640	692	8.7	7.4	5.8	7.2	7.8
1500-2000	176	115	76	121	104	2	1.3	0.8	1.4	1.2
2001-с дээш	76	50	25	35	34	0.9	0.6	0.3	0.4	0.4


Малтай өрхийг малын тоогоор бүлэглэн авч үзвэл нийт малтай өрхөд эзлэх хувиар авч үзвэл 31-50 хүртэлх малтай өрх 0.2 хувиар, 201-500 малтай өрх 0.1 хувиар, 501-999 малтай өрх 0.7 хувиар, 1000-1499 малтай өрх 0.6 хувиар өсч, 31-50 малтай өрх 0.1 хувиар, 51-100 малтай өрх 0.4 хувиар, 101-200 малтай өрх 0.9 хувиар, 1500-200 малтай өрх 0.2 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт.7. Өрх, ам бүлд ногдох мал, сумаар,

Сумд	Малтай өрх					Малчин өрх					Малтай нэг өрхөд ногдох мал (Толгой, тоогоор)	Малчин нэг өрхөд ногдох мал (Толгой, тоогоор)
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023		
Сайнцагаан	1016	1084	1084	1120	1090	831	883	893	928	912	345	386
Адаацаг	643	659	658	653	648	539	556	554	549	544	454	501
Баянжаргалан	295	300	295	284	282	234	249	255	249	240	469	526
Говь-Угтаал	357	369	371	368	371	279	282	283	289	287	504	610
Гурвансайхан	536	560	558	568	567	495	508	507	519	512	455	486
Дэлгэрхангай	582	611	594	581	573	406	453	452	433	428	311	375
Дэлгэрцогт	435	444	441	426	416	384	390	391	375	347	446	513
Дэрэн	497	512	521	533	541	428	445	453	466	455	496	565
Луус	418	447	453	450	440	362	363	392	398	383	421	468
Өлзийт	654	700	706	713	699	585	637	646	644	615	437	484
Өндөршил	360	376	371	357	354	269	292	292	294	285	442	524
Сайхановоо	509	518	516	520	521	402	410	437	430	428	375	426
Хулд	582	601	614	624	611	477	512	517	539	529	441	485
Цагаандэлгэр	315	324	315	314	311	273	272	270	261	260	445	498
Эрдэнэдалай	1394	1462	1445	1419	1397	1284	1346	1328	1308	1122	376	441
Дүн	8593	8967	8942	8930	8821	7248	7598	7670	7682	7347	414	471

Мянгаас дээш малтай малчин өрхийн тоо энэ онд 830 болж, өмнөх оноос 37 өрхөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Хамгийн олон мянгат малчинтай сумдаар Эрдэнэдалай сум 114 мянгат малчин өрх, Адаацаг сум 86 мянгат малчин өрх, Дэрэн сум 73 мянгат малчин өрх, Өлзийт сум 70 мянгат малчин өрх, Гурвансайхан сум 62 мянгат малчин өрх, Говь-Угтаал сум 56 мянгат малчин өрх, Сайнцагаан сум 55 мянгат малчин өрхтэй байна.

Зураг 4. 1000 дээш малтай өрхийн тоо сумдаар (2022-2023 он)



2.3. Малчдын мэдээлэл

2023 онд мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа малчдын тоо 11694 болж өмнөх оноос 6.0 хувь буюу 752 хүнээр буурсан байна. Аймгийн нийт иргэдийн 25.3 хувийг малчид эзэлж байна. Нийт малчдын 40.7 хувь буюу 4760 эмэгтэй, 59.3 хувь буюу 6934 эрэгтэй байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 23.5 хувь нь 15-34 нас, 62.4 хувь нь 35-59 нас, 14.1 хувь нь 60-аас дээш насны тэтгэврийн хүмүүс байна. Нийт малчдын 1.6 хувь буюу 188 нь туслах малчин байна

Хүснэгт 8. Малтай өрх, малчин өрх, малчдын мэдээлэл, онуудаар

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2023/ 2022
Малтай өрх	7503	7947	8283	8466	8593	8697	8942	8930	8821	98.8
Малчин өрх	6181	6590	7001	7159	7248	7598	7670	7682	7347	95.6
Малчдын тоо	11633	12171	12222	12136	12241	12505	12536	12446	11694	94.0
Үүнээс: 15-34 насны	3868	3948	4021	3870	3669	3520	3259	3118	2746	88.1
35-59 насны	6426	6748	6772	6865	7107	6997	7593	7607	7296	95.9
60+	1339	1475	1429	1401	1465	1988	1684	1721	1652	96.0
Нийт малчидаас эмэгтэй	5274	5485	5361	5210	5210	5254	5265	5218	4760	91.2
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	447	464	513	534	564	467	394	451	471	104.4

Зураг 5. Үндсэн болон туслах малчдын тоо (5 жилээр)




Малчдыг насны бүлгээр өмнөх онтой харьцуулж үзэхэд 15-34 насны малчид 11.9 хувиар, 35-60 насны малчид 4.1 хувиар, 60-с дээш буюу тэтгэврийн насны малчид 4.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Малчдын тоо (10 жилээр)

Сумд	Нийт малчдын тоо									
	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Сайнцагаан	1245	1294	1362	1401	1371	1375	1423	1423	1413	1264
Адаацаг	960	944	993	966	940	962	932	919	927	907
Баянжаргалан	337	330	326	380	365	369	399	393	378	370
Говь-Угтаал	493	509	507	512	482	489	483	477	488	477
Гурвансайхан	725	737	773	776	764	808	831	805	829	834
Дэлгэрхангай	628	631	672	714	687	700	749	730	694	671
Дэлгэрцогт	547	572	600	623	610	609	584	578	549	500
Дэрэн	764	783	806	758	799	793	836	835	834	796
Луус	586	631	638	651	672	640	663	695	702	675
Өлзийт	792	823	873	904	960	984	1030	1018	995	943
Өндөршил	387	404	420	414	440	432	467	473	473	450
Сайхан-Овоо	635	694	769	742	713	706	705	731	729	728
Хулд	671	783	839	767	775	811	833	820	841	777
Цагаандэлгэр	369	395	387	384	392	406	404	398	378	371
Эрдэнэдалай	2075	2103	2206	2230	2166	2157	2166	2241	2216	1931
Дүн	11214	11633	12171	12222	12136	12241	12505	12536	12446	11694

Зураг 6. Малчдын насны бүтэц, хувиар, онуудаар



Малчдын насны бүтцийг сумдаар авч үзвэл 15-34 насны залуучууд Өндөршил, Дэрэн, Адаацаг, Сайхан-Овоо сумдууд 25.5-27.1 хувийг, 35-59 насны идэрчүүд Дэлгэрхангай, Гурвансайхан, Говь-Угтаал, Эрдэнэдалай сумдууд 64.4-65.4 хувийг, тэтгэврийн насныхан Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Сайнцагаан сумдууд 17.2-22.4 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн **өндөр** үзүүлэлттэй байна. Малчдын хүйсийн харьцааг авч үзвэл аймгийн хэмжээнд 100 эмэгтэй малчинд 146 эрэгтэй малчин ноогдож байгаа нь хүйсийн харьцаа хөдөөд алдагдаж байгааг харуулж байна.


Хүснэгт 10. Малчдын тоо, насны бүлгээр, 2023 оны жилийн эцсийн байдлаар

Сумд	Нийт малчдын тоо	15-34	35-59	60+	Хувиар			Нийт малчдаас эрэгтэй	Нийт малчдаас эмэгтэй	Малчдын хүйсийн харьцаа
					15-34	35-59	60+			
Сайнцагаан	1264	264	783	217	20.9	61.9	17.2	790	474	167
Адаацаг	907	235	575	97	25.9	63.4	10.7	526	381	138
Баянжаргалан	370	84	231	55	22.7	62.4	14.9	214	156	137
Говь-Угтаал	477	86	308	83	18.0	64.6	17.4	268	209	128
Гурвансайхан	834	170	542	122	20.4	65.0	14.6	474	360	132
Дэлгэрхангай	671	160	439	72	23.8	65.4	10.7	398	273	146
Дэлгэрцогт	500	113	299	88	22.6	59.8	17.6	308	192	160
Дэрэн	796	213	452	131	26.8	56.8	16.5	472	324	146
Луус	675	164	403	108	24.3	59.7	16.0	398	277	144
Өлзийт	943	236	576	131	25.0	61.1	13.9	566	377	150
Өндөршил	450	122	273	55	27.1	60.7	12.2	267	183	146
Сайхан-Овоо	728	186	464	78	25.5	63.7	10.7	429	299	143
Хулд	777	182	485	110	23.4	62.4	14.2	508	269	189
Цагаандэлгэр	371	65	223	83	17.5	60.1	22.4	225	146	154
Эрдэнэдалай	1931	466	1243	222	24.1	64.4	11.5	1091	840	130
Дүн	11694	2746	7296	1652	23.5	62.4	14.1	6934	4760	146

2.4. Малчдын нийгэм соёлын зарим үзүүлэлт


2023 оны байдлаар нийт малчдын 8302 буюу 71.0 хувь нь гэрлэлтээ батлуулсан, 963 буюу 8.2 хувь нь гэрлэсэн батлуулаагүй байна. Харин 1620 малчин буюу 13.9 хувь нь огт гэрлээгүй, 191 малчин буюу 1.6 хувь нь тусгаарласан, 121 малчин буюу 1 хувь нь цуцалсан, 497 буюу 4.3 хувь нь бэлэвсэн байна.

Зураг.7 Малчдын гэрлэлтийн байдал



Малчдын боловсролын түвшинг 2023 оны байдлаар авч үзэхэд 5097 малчин буюу 44.0 хувь нь суурь, 2933 малчин буюу 25.0 хувь нь бага, 2064 малчин буюу 18.0 хувь нь бүрэн дунд, 461 малчин буюу 4.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 329 малчин буюу 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой байгаа бол 350 буюу 3.0 хувь нь боловсролгүй, 460 малчин буюу 4.0 хувь нь дээд боловсролтой байна.

Зураг.8 Малчдын боловсролын түвшин



2023 оны байдлаар нийт малчдын 60.2 хувь буюу 7036 малчин зээлтэй байна. Мөн малчдын 54.6 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол 35.3 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна.

Хүснэгт 11. Малчдын нийгмийн зарим үзүүлэлтүүд-2023

Сумд	Зээлтэй малчин	Нийт малчдад эзлэх хувь	ЭМД-д хамрагддаг малчин	Нийт малчдад эзлэх хувь	НД-д хамрагддаг малчин	Нийт малчдад эзлэх хувь
Сайнцагаан	671	53.1	780	61.7	493	39
Адаацаг	689	76.0	484	53.4	349	38.5
Баянжаргалан	247	66.8	261	70.5	160	43.2
Говь-Угтаал	271	56.8	272	57	208	43.6
Гурвансайхан	413	49.5	316	37.9	198	23.7
Дэлгэрхангай	456	68.0	411	61.3	352	52.5
Дэлгэрцогт	359	71.8	345	69	262	52.4
Дэрэн	486	61.1	419	52.6	179	22.5
Луус	299	44.3	208	30.8	124	18.4
Өлзийт	665	70.5	536	56.8	294	31.2
Өндөршил	180	40.0	166	36.9	128	28.4
Сайхан-Овоо	483	66.3	423	58.1	194	26.6
Хулд	502	64.6	376	58.4	337	43.4
Цагаандэлгэр	226	60.9	230	62	207	55.8
Эрдэнэдалай	1089	56.4	1158	60	642	33.2
Нийт дүн	7036	60.2	6385	54.6	4127	35.3


2023 оны мал тооллогын дүнгээр аймгийн нийт малчин өрхийн 85.8 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 80.4 хувь нь телевизортой, 63.7 хувь нь автомашинтай, 57.7 хувь нь мотоциклтой, 97.7 хувь нь гар утас хэрэглэдэг гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

Хүснэгт 12. Малчдын ахуй соёлын зарим үзүүлэлтүүд-2023

Үзүүлэлт	Өрхийн тоо					Малчин өрхөд эзлэх хувь					2023/2022
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023	
Малчин өрх	7248	7598	7670	7682	7347	-	-	-	-	-	-
Цахилгаантай	5722	5998	6384	6407	6306	78.9	78.9	83.2	83.4	85.8	2.4
Телевизортой	5349	5642	6071	6080	5907	73.8	74.2	79.2	79.1	80.4	1.3
Автомашинтай	3856	4282	4345	4653	4679	53.2	56.4	56.6	60.6	63.7	3.1
Мотоциклтой	4083	3897	3746	4384	4237	56.3	51.3	48.8	57.1	57.7	0.6
Гар утастай	7248	7318	7504	7523	7181	100	96.3	97.8	97.9	97.7	-0.2


Нийт өрхийн дүнд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулбал автомашинтай өрх 3.1 хувиар, цахилгаантай өрх 2.4 хувиар, телевизортой өрх 1.3 хувиар, мотоциклтой өрх 0.6 хувиар тус тус өсч, гар утастай өрх 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг.9 Малчдын ахуй соёлын зарим үзүүлэлт, сүүлийн 5 жилээр





МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ



МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ




3. МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, БҮТЭЦ

3.1. Малын тоо, бүтэц


Дундговь аймаг 2023 оны жилийн эцэст 3661115 толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 34745 толгой буюу 1.0 хувиар өссөн байна. Үүний дотор тэмээ 2570 толгой буюу 6.2 хувиар, адуу 11576 толгой буюу 6.3 хувь, үхэр 10985 толгой буюу 14.7 хувь, хонь 35731 толгой буюу 2.1 хувиар тус тус өсч, ямаа 26117 толгой буюу 1.6 хувиар буурсан байна. Нийт мал сүргийн 1.2 хувь нь буюу 43708 тэмээ, 2.3 хувь нь буюу 85520 үхэр, 5.3 хувь нь буюу 194643 адуу, 43.1 хувь буюу 1577298 ямаа, 48.1 хувь буюу 1759946 мянга нь хонин сүрэг байна. Тэмээний тоогоор 21 аймгаас 5-р байрт орсон байна.

Зураг 10 Малын тоо, сая толгой (1942-2023)

МАЛЫН ТОО, МЯНГАН ТОЛГОЙГООР



Зураг.11 Сумдын малын тоо




Аймгийн хамгийн олон малтай сумаар Эрдэнэдалай сум 525629 толгой, Сайнцагаан сум 376228 толгой, Өлзийт сум 305504 толгой, Адаацаг сум 295549 толгой, Хулд сум 269533 толгой мал тоолуулж тэргүүлсэн /Зураг.12/ бол Эрдэнэдалай сум улсын хэмжээнд малын тоогоор **хоёрдугаар** байранд орсон байна. Өлзийт сум улсын хэмжээнд тэмээний тоогоор дөрөвдүгээр байранд, Эрдэнэдалай сум улсын хэмжээнд хонины тоогоор дөрөвдүгээр, ямааны тоогоор хоёрдугаар байранд тус тус орлоо. /Зураг13/

Хүснэгт 13. 2023 оны жилийн эцсийн малын тоо, сумдаар, төрлөөр


Сумд	Бүгд	Үүнээс				
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Сайнцагаан	376 228	1 036	21 199	7 866	179 402	166 725
Адаацаг	295 549	840	17 695	8 460	146 021	122 533
Баянжаргалан	132 320	312	7 286	4 070	70 316	50 336
Говь-Угтаал	186 997	570	9 130	4 046	96 212	77 039
Гурвансайхан	258 104	2 453	10 872	5 918	132 943	105 918
Дэлгэрхангай	178 365	5 181	8 751	2 513	67 350	94 570
Дэлгэрцогт	186 950	659	8 507	5 677	89 707	82 400
Дэрэн	269 493	1 705	14 071	5 988	134 858	112 871
Луус	185 239	757	11 051	5 714	84 893	82 824
Өлзийт	305 504	16 827	14 316	3 359	134 331	136 671
Өндөршил	156 525	3 551	13 144	4 493	75 253	60 084
Сайхан-овоо	195 934	787	9 337	3 729	87 271	94 810
Хулд	269 533	7 216	13 686	3 513	127 582	117 536
Цагаандэлгэр	138 745	635	9 666	3 965	72 585	51 894
Эрдэнэдалай	525 629	1 179	25 932	16 209	261 222	221 087
Дүн	3 661 115	43 708	194 643	85 520	1 759 946	1 577 298

Зураг 12. Нийт малын тоо, сумдаар, 2023 оны жилийн эцсийн байдлаар




2023 оны эцэст 10 сумын малын тоо өсч, үүнээс Сайхан-Овоо сум 7.4 хувь, Дэрэн сум 6.3 хувь, Дэлгэрцогт сум 6.0 хувь, Говь-Угтаал сум 5.9 хувь ба бусад сумдад 4.8-0.1 хувиар тус тус өссөн байна. Цагаандэлгэр, Хулд, Дэлгэрхангай, Өндөршил, Өлзийт сумдад 1.2-7.1 хувиар бурсан байна.

Зураг.13 Малын тооны өөрчлөлт сумдаар, хувиар, 2023 он



Нийт мал сүрэгт хонь 48.1 хувь, ямаа 43.1 хувь, адуу 5.3 хувь, үхэр 2.3 хувь, тэмээ 1.2 хувийг эзэлж байна. Энэ оныг 1990 онтой харьцуулж үзэхэд нийт сүрэгт эзлэх хонины хувь 10.2 хувиар буурч, ямааны эзлэх хувь 23.3 хувиар өссөн бол адууны эзлэх хувь 3.4 хувиар, үхрийн эзлэх хувь 8.7 хувиар, тэмээний эзлэх хувь 0.9 хувиар тус тус буурсан байна.

Зураг 14. Нийт малын тоо сүргийн бүтэц, хувиар



Хүснэгт 14. Нийт сүрэгт малын таван төрлийн эзлэх хувь, жил бүрийн эцсийн байдлаар

Бүгд	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
	100	100	100	100	100	100	100	100	100	100
Тэмээ	1.1	1.1	1.1	1	1	1	1.1	1.2	1.1	1.2
Адуу	4.3	4.5	4.5	4	4	4	4.4	5	5	5.3
Үхэр	1.9	2	2	2	2	2	2	2.1	2.1	2.3
Хонь	45.8	45.8	47	47	48	48	47.9	48.4	47.6	48.1
Ямаа	46.9	46.6	45.4	46	45	45	44.6	43.3	44.2	43.1

Хүснэгт 15. Хамгийн олон мал тоолуулсан сум, баг

Нийт малын тоогоор, толгой

Сумын түвшинд	Тоо	Багийн түвшинд	тоо
Эрдэнэдалай	525629	Эрдэнэдалай	5-р баг, Цагаан-Овоо
Сайнцагаан	376228	Эрдэнэдалай	4-р баг, Рашаант
Өлзийт	305504	Сайнцагаан	3-р баг, Далай
Адаацаг	295549	Адаацаг	4-р баг, Сүм
Хулд	269533	Эрдэнэдалай	2-р баг, Өнгөт

Адууны тоогоор, толгой

Сумын түвшинд	Тоо	Багийн түвшинд	тоо
Эрдэнэдалай	25932	Өндөршил	1-р баг, Цог
Сайнцагаан	21199	Өндөршил	2-р баг, Талын нар
Адаацаг	17695	Адаацаг	4-р баг, Сүм
Өлзийт	14316	Сайнцагаан	2-р баг, Тэвш
Дэрэн	14071	Эрдэнэдалай	5-р баг, Цагаан-Овоо

Үхрийн тоогоор, толгой

Сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо
Эрдэнэдалай	16209	Эрдэнэдалай	4-р баг, Рашаант
Адаацаг	8460	Эрдэнэдалай	5-р баг, Цагаан-Овоо
Сайнцагаан	7866	Эрдэнэдалай	6-р баг, Сангийн далай
Дэрэн	5988	Эрдэнэдалай	2-р баг, Өнгөт
Гурвансайхан	5918	Өндөршил	1-р баг, Цог

Тэмээний тоогоор, толгой

Сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо
Өлзийт	16827	Хулд	2-р баг, Олдох
Хулд	7216	Өлзийт	2-р баг, Буянт 2
Дэлгэрхангай	5181	Өлзийт	3-р баг, Тагт
Өндөршил	3551	Өлзийт	1-р баг, Буянт 1
Гурвансайхан	2453	Өлзийт	5-р баг, Дэрт 2

Хонины тоогоор, толгой

Сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо
Эрдэнэдалай	261222	Эрдэнэдалай	5-р баг, Цагаан-Овоо
Сайнцагаан	179402	Эрдэнэдалай	4-р баг, Рашаант
Адаацаг	146021	Сайнцагаан	3-р баг, Далай
Дэрэн	134858	Сайнцагаан	2-р баг, Тэвш
Өлзийт	132943	Адаацаг	4-р баг, Сүм

Ямааны тоогоор, толгой

Сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо
Эрдэнэдалай	221087	Эрдэнэдалай	5-р баг, Цагаан-Овоо
Сайнцагаан	166725	Эрдэнэдалай	4-р баг, Рашаант
Өлзийт	136671	Эрдэнэдалай	2-р баг, Өнгөт
Адаацаг	122533	Сайнцагаан	3-р баг, Далай
Хулд	117536	Өлзийт	2-р баг, Буянт 2

3.2. Хээлтэгч малын тоо

Хүснэгт 16. Хээлтэгч мал, 10-н төрлөөр, мянган толгой, жил бүрийн эцсийн байдлаар

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2023/2022	
											хувь	зөрүү
Ингэ	10.9	12.2	13	14.3	15.4	16.3	16.5	16.8	17.5	18.6	106.3	1.1
Гүү	31.3	37.6	43.1	51.8	56.6	61.4	61.4	62.5	70.2	74.8	106.6	4.6
Үнээ	17.8	21.2	24.5	29.6	30.6	32.9	31.8	32.8	33.9	36.2	106.8	2.3
Эм хонь	484.1	552	639.1	741.2	821.9	847.4	827.6	843.9	777.5	838.1	107.8	60.6
Эм ямаа	458.9	522.2	592.5	665.6	729	754.8	735.6	754	664.4	716.5	107.8	52.1
Бүгд	1,003.0	1,145.2	1,312.2	1,502.5	1,653.5	1,712.8	1,672.9	1,710.0	1,563.5	1,684.2	107.7	120.7

Хээлтэгч мал өмнөх оноос 7.7 хувь буюу 120.7 мянган толгой малаар өсч 1684.2 мянган толгойд хүрсэн байна. Үүнд: Ингэ 6.3 хувиар, гүү 6.6 хувь, үнээ 6.8 хувь өсч, эм хонь 7.8 хувь, эм ямаа 7.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 17. Хээлтэгч мал, 5 төрлөөр нийт малд эзлэх хувь

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	Зөрүү
Тэмээ	38.9	39.6	38.3	38.9	39.1	39.6	39.5	42.6	42.6	42.6	0.0
Адуу	29.8	30.4	31.5	32.3	34.8	34.5	36.9	39.4	38.3	38.4	0.1
Үхэр	38.8	38.6	39.1	39.3	40.3	42.1	42.3	49.9	45.5	42.3	-3.2
Хонь	43.4	43.6	44.5	44	44.9	43.6	46.2	55	45.1	47.6	2.5
Ямаа	40.2	40.5	42.7	40.7	42.5	40.7	44.1	54.9	41.4	45.4	4.0
Нийт малын тоо	41.2	41.4	42.9	41.8	43.2	41.8	44.7	53.9	43.1	46.0	2.9

Хээлтэгч мал нь нийт малын 46.0 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 42.6 хувь, адуун сүргийн 38.4 хувь, үхэр сүргийн 42.3 хувь, хонин сүргийн 47.6 хувь, ямаан сүргийн 45.4 хувийг тус тус эзэлж байна.

2023 онд нэг хуцанд 63, нэг ухнанд 66 хээлтэгч ноогдож байгаа нь үржлийн нормоос өндөр байна. Харин бод малд үржлийн нормоор нэг хээлтүүлэгчид 12-46 хээлтэгч

ноогдох ёстой бол нэг бууранд 46, азарганд 10, буханд 29 хээлтэгч ноогдож байгаа нь үржлийн норм алдагдаж байна.

Хүснэгт 18. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо

Төрөл	Үржлийн норм	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Ингэ	20-25	34	35	33	37	39	40	44	40	44	46
Гүү	12.-15	9	9	9	10	10	10	10	10	10	10
Үнээ	35-45	30	32	35	31	31	34	36	34	29	29
Эм хонь	25-30	64	66	70	67	71	66	69	72	60	63
Эм ямаа	25-30	63	66	77	70	79	70	74	79	62	66

Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироог өмнөх онтой харьцуулахад ингэ 2, эм хонь 3, эм ямаа 4 хээлтэгчээр тус тус өссөн байна.


3.3. Төл бойжилт

2023 оны байдлаар оны эхний эх малын 83.0 хувь буюу 1298.1 мянган эх мал төллөж, гарсан төлийн 90.0 хувь буюу 1173.0 мянган төл бойжуулсан байна.

Хүснэгт 19. Бойжуулсан төл, мянган толгой, жил бүрийн эцсийн байдлаар


Үзүүлэлт	Он										
	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	
Гарсан төл	816.2	977	1,009.0	1259.9	1336.8	1433.4	1184.4	973.5	1424.7	1302.9	
Бойжсон төл	814.4	970.9	974.7	1249.1	1173.7	1410.9	1122.9	613.6	1413.9	1173	
Бойжилтын хувь	99.8	99.8	96.6	99.1	87.8	98.4	94.8	63.1	99.2	90.0	

Зураг 15. Бойжуулсан төл 8 мянган толгойгоор



Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 240.9 мянган толгой буюу 17 хувиар буурсан байна. Мөн төл бойжилтын хувь өмнөх онтой харьцуулбал 9.2 хувиар буурчээ. Аймгийн дүнгээр 100 эхээс 75 төл бойжуулсан нь өмнөх оноос 12 төлөөр буурсан байна.


Зураг16. 100 эхээс бойжуулсан төл



3.4. Том малын зүй бус хорогдол

2023 онд нийт малын 1.3 хувьтай тэнцэх 48273 толгой мал хорогдсон нь өмнөх оноос 10.5 дахин буюу 43697 толгойгоор буурсан үзүүлэлт байна.

Зураг17. Хорогдол том мал



Нийт хорогдсон малын 60.2 хувийг ямаа, 33.2 хувийг хонь, 3.8 хувийг адуу, 2.3 хувийг үхэр, 0.5 хувийг тэмээ эзэлж байна.

Хүснэгт 20. Хорогдсон том мал, 5-н төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар


Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Тэмээ	24	63	56	13	64	31	116	1944	52	214
Адуу	60	159	2,425	153	5298	422	1539	10136	199	1809
Үхэр	117	158	2,078	98	5189	324	879	8790	186	1127
Хонь	869	1,382	20,670	1813	27819	4354	11855	228732	1488	16047
Ямаа	752	2,038	44,495	1285	37049	9054	18667	241474	2651	29076
Бүгд	1,822	3,800	69,724	3362	75419	14185	33056	491076	4576	48273

2023 онд том малын хорогдлыг сумдаар авч үзвэл Өлзийт 8296, Адаацаг 6502, Эрдэнэдалай 6105, Луус 4785, Сайнцагаан 3675 толгой мал хорогдсон нь өндөр үзүүлэлт байна.

Хүснэгт 21. Сумдаар, том малын зүй бус хорогдол

Сумд	2023 онд хорогдсон том мал						Хорогдолын хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Сайнцагаан	3675	196	73	0	1318	2088	1.0	18.9	0.3	0.0	0.7	1.3
Адаацаг	6502	261	187	6	2305	3743	2.2	31.1	1.1	0.1	1.6	3.1
Баянжаргалан	359	10	4	0	104	241	0.3	3.2	0.1	0.0	0.1	0.5
Говь-Угтаал	712	28	8	14	344	318	0.4	4.9	0.1	0.3	0.4	0.4
Гурвансайхан	1778	58	10	2	668	1040	0.7	2.4	0.1	0.0	0.5	1.0
Дэлгэрхангай	7110	427	190	55	2326	4112	4.0	8.2	2.2	2.2	3.5	4.3
Дэлгэрцогт	2941	44	43	5	1053	1796	1.6	6.7	0.5	0.1	1.2	2.2
Дэрэн	19	0	5	5	6	3	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0
Луус	4785	230	178	12	1437	2928	2.6	30.4	1.6	0.2	1.7	3.5
Өлзийт	8296	139	87	45	3016	5009	2.7	0.8	0.6	1.3	2.2	3.7
Өндөршил	3634	195	167	23	1229	2020	2.3	5.5	1.3	0.5	1.6	3.4
Сайхан-Овоо	1392	32	34	7	381	938	0.7	4.1	0.4	0.2	0.4	1.0
Хулд	46	0	0	23	13	10	0.0	0.0	0.0	0.7	0.0	0.0
Цагаандэлгэр	919	31	16	6	239	627	0.7	4.9	0.2	0.2	0.3	1.2
Эрдэнэдалай	6105	158	125	11	1608	4203	1.2	13.4	0.5	0.1	0.6	1.9
Бүгд	8273	1809	1127	214	16047	29076	1.3	4.1	0.6	0.3	0.9	1.8

Зураг18. Том малын хорогдол сумдаар 2023 оны жилийн эцсийн байдлаар



3.5. Малын хээл хаялт, сувайралт

Энэ онд оны эхний хээлтэгч малын 18.5 хувь 288512 эх мал хээл хаяж, сувайрсан. Үүнээс 28145 мал хээл хаясан нь өмнөх онтой харьцуулахад 25137 толгойгоор буюу 9.4 дахин өссөн үзүүлэлттэй бол 260367 мал сувайрсан нь өмнөх онтой харьцуулахад 17.9 хувиар буюу 39557 толгойгоор өсчээ. Нийт хээл хаясан малын 68.2 хувь, сувайрсан эх малын 45.2 хувийг ямаа эзэлж байна.

Хүснэгт 22. Хээл хаясан болон сувайрсан эх малын тоо, 5-н төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар

	Хээл хаясан малын тоо			2023 /2022	Сувайрсан малын тоо			2023 /2022
	2021	2022	2023		2021	2022	2023	
Бүгд	60416	3008	28145	935.7	576484	220810	260367	117.9
Гүү	2972	135	2751	2037.8	26024	13578	23995	176.7
Үнээ	455	63	165	261.9	12596	6671	7351	110.2
Ингэ	19	27	172	637.0	900	808	410	50.7
Эм хонь	12309	1249	5876	470.5	264388	95793	110995	115.9
Эм ямаа	44661	1534	19181	1250.4	272576	103960	117616	113.1

3.6. Малын хэрэглээний зарлага

2023 онд оны эхний нийт малын 24.7 хувьтай тэнцэх 895.8 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос 57.6 мянган толгой буюу 6.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 23. Малын хэрэглээний зарлага(мян.тол)

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Тэмээ	2.4	3	3.3	7.6	5	5.9	7.1	6.6	7	5.5
Адуу	7.1	9.8	11.7	15.6	21.3	26.3	38	21.6	28.16	23
Үхэр	5.6	8.7	8.7	11.5	15	19.9	23.3	14.7	16.18	13.6
Хонь	195.6	320.1	309.3	343.3	455.4	615.8	671.9	357	525.56	493.8
Ямаа	170.7	297.2	276.6	295.9	368.5	461.6	545.7	228.6	376.5	359.9
Бүгд	381.4	638.8	609.5	673.9	865.4	1129.5	1286	628.5	953.4	895.8

Оны эхний нийт малын 5.6 хувь буюу 204399, тэмээний 2.1 хувь буюу 878, адууны 2.9 хувь буюу 5324, үхрийн 6.8 хувь буюу 5044, хонины 5.9 хувь буюу 102532, ямааны 5.7 хувь буюу 90621-г хүнсний хэрэглээнд зарцуулсан байна.

3.7. Сүргийн бүтэц

2023 оны байдлаар нийт сүргийн 28.7 хувь буюу 1051.8 мянган толгой нь төл өсвөр насны мал, 24.4 хувь буюу 892.1 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 46.0 хувь буюу 1684.1 мянган толгой нь хээлтэгч, 0.9 хувь буюу 33.1 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

Хүснэгт 24. Сүргийн бүтэц, 5-н төрлөөр, мянган толгой, 2023 оны жилийн эцсийн байдлаар

Малын төрөл	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтүүлэгч	Хээлтэгч
Тэмээ	43708	20115	4605	406	18582
Адуу	194643	82013	30341	7474	74815
Үхэр	85520	41186	6926	1240	36168
Хонь	1759946	545609	363038	13227	838072
Ямаа	1577298	362897	487149	10779	716473
Нийт	3661115	1051820	892059	33126	1684110

Хүснэгт 25. Сүргийн бүтэц, 5-н төрлөөр, хувиар, 2023 оны жилийн эцсийн байдлаар

Малын төрөл	бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтүүлэгч	Хээлтэгч
Тэмээ	100	46.0	10.5	0.9	42.5
Адуу	100	42.1	15.6	3.8	38.4
Үхэр	100	48.2	8.1	1.4	42.3
Хонь	100	31.0	20.6	0.8	47.6
Ямаа	100	23.0	30.9	0.7	45.4
Нийт	100	28.7	24.4	0.9	46.0

3.8. Тэжээвэр амьтад

2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 138 гахай, 12032 шувуу тоологдсон нь өмнөх оноос гахай 6.1 хувиар буурч, шувуу 2.4 дахин өссөн байна.

Хүснэгт 26. Тэжээвэр амьтдын тоо, сумдаар, 2023 оны жилийн эцсийн байдлаар

Сумд	Бүгд	Гахай	Тахиа	Галуу
Сайнцагаан	12087	87	12000	0
Говь-Угтаал	28	28	0	0
Гурвансайхан	15	15	0	0
Дэлгэрхангай	40	8	30	2
Нийт	12170	138	12030	2

3.8.1. Тэжээвэр амьтдын бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Гахайн мах 0.21 тн, өндөг 1200.0 мянган ширхэгийг үйлдвэрлэж зах зээлд борлуулсан байна. Өмнөх оноос гахайн мах 0.2 тн, өндөг 1196.0 мянган ширхэг борлуулалт өссөн байна.

Хүснэгт 27. Тэжээвэр амьтдын тоо, 5 жилээр

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2023/ 2022
Гахай	90	71	46	131	147	138	93.9
Шувуу	46	68	46	51	5025	12032	2.4*
Тахиа	33	55	40	42	5023	12030	2.4*
Галуу	11	9	2	4	2	2	100.0
Цацагт хяруул	2	4	4	5	0	0	0.0
Бусад	11	11	2	0	0	0	0.0
Бүгд	147	150	94	182	5172	12170	2.4*

* дахин их

4. МАЛЖУУЛАЛТ, ХУДАГ УСНЫ ТАЙЛАН

4.1. Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан

Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон цөөн малтай иргэдийг малжуулах арга хэмжээг авч, нэлээдгүй хөрөнгө, мөнгийг зарцуулж байна. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна.

Хүснэгт 28. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрх, ам бүл, малын тоо

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Өрхийн тоо	320	317	279	236	278	196	135	62	131	62
Ам бүлийн тоо	1204	1150	955	803	901	671	405	208	453	225
Малын тоо	11205	12734	10633	10462	12208	7503	5782	2512	5358	3243

2023 онд малжуулах арга хэмжээнд 62 өрх хамрагдсан ба өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 69 өрхөөр буюу 111.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 29. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрх, ам бүл, малын тоо, сум

Сум	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мянган төгрөгөөр/	Малжуулалтаар авсан малын тоо	Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо	Малжуулалтанд хамрагдсан ам бүлийн тоо
Сайнцагаан	25000	250	5	18
Адаацаг	27000	343	7	23
Баянжаргалан	5000	60	1	2
Гурвансайхан	49070	318	8	27
Дэлгэрхангай	27870	416	8	38
Дэлгэрцогт	20000	581	8	27
Өндөршил	5000	66	1	3
Сайхан-Овоо	5000	40	1	4
Хулд	15000	156	3	11
Цагаандэлгэр	40000	660	13	55
Эрдэнэдалай	41000	353	7	17
Дүн	259940	3243	62	225

Малжуулах арга хэмжээгээр 62 өрхөд нийт 3243 толгой мал олгогдсон байна. Нэг өрхөд дунджаар 52 толгой мал олгожээ. Хамгийн олон өрх малжуулсан сумдаар Цагаандэлгэр 13, Гурвансайхан 8, Дэлгэрцогт 8, Дэлгэрхангай 8 өрхийг тус тус малжуулах төсөлд хамруулсан байна.

Хүснэгт 30. Малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, 2023 оны жилийн эцсийн байдлаар

	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. Төг /					Үүнээс: (2023 он)		
						Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн үзэмж мян. Төг	Орон нутгийн хөрөнгө мян. төг	Бусад мян. Төг
	2019	2020	2021	2022	2023			
Дүн	680	563	298.8	562.75	259.9	30000	89070	140870

4.2. Шинээр гаргасан, засварласан худаг

Монгол Улсын Засгийн газраас усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

2023 онд 47 худаг шинээр ашиглалтанд орсноос инженерийн хийцтэй 44, энгийн уурхайн 3 худаг байна.

Хүснэгт 31. Шинээр гаргасан худгийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Шинээр гаргасан худгийн тоо, бүгд	53	71	70	29	53	33	43	19	83	47
Үүнээс: Инженерийн хийцтэй	46	47	67	27	49	29	42	15	76	44
Энгийн уурхайн	7	24	3	2	4	4	1	4	7	3

Хүснэгт 32. Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө, 2023 оны жилийн эцсийн байдлаар

Он	Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, сая төг										Үүнээс: /2023 он, сая төг/		
	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	Улсын төсвийн хөрөнгөөр	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн үзэмж мян. Төг	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
Дүн	674	585.4	558.6	223.1	472	421.9	424.2	448.8	1143	865.1	706.5	61	97.6

5. ГАЗАР ТАРИАЛАН

Аймгийн хэмжээгээр 2023 онд төмс 23.6 га, хүнсний ногоо 23.1 га нийт 46.7 га-д тариалалт хийсэн байна.

Хүснэгт 33. Газар тариалангийн үйлдвэрлэл, хураасан ургац, жилийн эцсийн байдлаар

Он	Хураасан ургац (тонн)					2023/2022	
	2019	2020	2021	2022	2023	Хувь	Зөрүү
Төмс	186.9	246.1	163	227.8	188.5	82.7	-39.3
Хүнсний ногоо	90.6	118.3	157.56	182.8	208.3	113.9	25.5
Гар тэжээл	4,863.30	1005.2	4153.12	3256.05	3256.05	2232.78	68.6

2023 онд аймгийн хэмжээнд 188.5 тонн төмс, 208.3 тонн хүнсний ногоо хураан авч, 2232.8 тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

Хүснэгт 34. Хураасан ургац бэлтгэсэн хадлан тэжээл, жилийн эцсийн байдлаар, сумдаар

Сумд	2022 он				2023 он				Бэлтгэсэн гар тэжээл (тонн)	
	Төмс		Хүнсний ногоо		Төмс		Хүнсний ногоо		2022	2023
	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)		
Адаацаг	7.884	124.58	4.411	114.27	8.8	135.4	7.2	142.6	74.5	138.5
Баянжаргалан	0.432	1.465	0.664	1.853	0.7	2	0.889	2.867	31.6	98.5
Говь-Угтаал	1	4.23	0.9	3.846	1	0.8	0.8	1.121	5.7	8.6
Гурвансайхан	1.8	0	2.871	2.218	1.09	0.375	0.223	0.44	14.8	32.23
Дэлгэрхангай	0	0	0.033	1.067	0	0	2.41	3.4	54.3	94
Дэлгэрцогт	0.7	4.2	0.505	2.27	1.5	7.1	0.7	4.2	9.4	3.8
Дэрэн	2.3	19.18	1.235	9.901	2.2	0	1.039	2.036	381.1	110.1
Луус	1.696	8.1	1.177	7.014	1.713	2.146	1.675	3.767	601.1	698.6
Өндөршил	0.098	3.87	0.05	2.178	0.365	3.65	0.366	1.96	118.3	110
Өлзийт	1.3	1.27	0.683	2.32	0	0	0.3	0.3	37.8	0
Сайнцагаан	0	0	0	0	0.046	0.575	0.348	1.948	6	182.15
Сайхан-Овоо	5.8	28.6	4.771	12.04	2.9	15	3.6	21.3	6	15.3
Хулд	1.1	10	0.9	3.955	0.148	2.7	0.065	4.28	1	0
Цагаандэлгэр	1.15	1.51	1.46	1.89	1.1	0.5	1.5	0.1	5.7	13.5
Эрдэнэдалай	3.078	20.8	2.026	18.01	2	18.2	2	17.94	1908.8	727.5
Дүн	28.34	227.8	21.69	182.84	23.56	188.5	23.1	208.3	3256.1	2232.8

Дүгнэлт

Аймгийн хэмжээнд малтай 8821 өрх тоологдсоны 7347 өрх буюу 83.3 хувь нь жилийн дөрвөн улирлын турш малаа маллаж байгаа **малчин** өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 11694 малчид ажиллаж байна. Нийт малчдыг насны бүлгээр авч үзвэл 23.5 хувь нь 15-34 нас, 62.4 хувь нь 35-59 нас, 14.1 хувь нь 60-аас дээш насны тэтгэврийн хүмүүс байна. Жил бүрийн тооллогын дүнгээс харахад сүүлийн жилүүдэд малчдын тоо өсч байгаа хэдий ч нийт малчдын дунд залуу малчдын эзлэх хувийн жин буурч, 35-аас дээш насны малчдын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь цаашид мал аж ахуйн салбарт ажиллах хүчин хомсдох, нүүдэлчдийн өв соёл, ёс заншил мартагдах, нутаг орон эзгүйрэх, төвлөрөл дагасан ажилгүйдэл нэмэгдэх гэх мэт сөрөг үр дагавартай. Тиймээс залуу малчдын тоо цөөрч байгаа шалтгаан нөхцөлд дүгнэлт хийж, зөв гарцыг тодорхойлон залуу малчдыг дэмжсэн үр дүнтэй ажил зохион байгуулах нь зүйтэй.

2023 оны нийт мал сүргийн 94.5 хувь буюу 3459.8 мянган толгой нь малчин өрхийн эзэмшилд байгаа бөгөөд нэг малчин өрхөд 471 толгой мал ногдож байна. Нийт малчин өрхийн 85.8 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 80.4 хувь нь телевизортой, 63.7 хувь нь автомашинтай, 57.7 хувь нь мотоциклтой, 97.7 хувь нь гар утас ашигладаг гэсэн үр дүн гарчээ. 2023 оны байдлаар нийт малчдын 60.2 хувь буюу 7036 малчин зээлтэй байна. Мөн малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 54.6 хувь байгаа бол нийгмийн даатгалд хамрагдалт 35.3 хувь байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 3661.1 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 1.0 хувь буюу 34.7 мянган толгойгоор өссөн байна. Нийт малын 91.2 хувийг бог мал, 8.8 хувийг бод мал эзэлж байна. Мал сүргийн бүтцэд хонь 48.1 хувь, ямаа 43.1 хувь, адуу 5.3 хувь, үхэр 2.3 хувь, тэмээ 1.2 хувийг эзэлж байна. Энэ оныг 1990 онтой харьцуулж үзэхэд нийт сүрэгт эзлэх ямааны эзлэх хувь 23.3 пунктээр өссөн, адууны эзлэх хувь 3.4 пунктээр, хонины хувь 10.2 пунктээр, үхрийн эзлэх хувь 8.7 пунктээр, тэмээний эзлэх хувь 0.9 нэгж хувиар тус тус буурсан байна.

Малчин өрхийн мал сүрэг нь удмын сангийн үнэт нөөц баялаг юм. Түүнийг өөр дотор нь цэврээр үржүүлэх нь чухал. Сүргийн сайн чанарыг хамгаалахын тулд үржил, селекци, технологийн ажлыг зөв зохиох шаардлагатай. Аймгийн хэмжээнд үржлийн хуц, ухны норм байх ёстой үзүүлэлтээс 2.0-2.3 дахин их байна. Хээлтүүлгийн тохироо алдагдсанаар хонь, ямаа сувайрах хандлага ажиглагдаж байна.

Мэдээллийн эх үүсвэр

1. Монгол улсын статистикийн эмхэтгэл 2013-2023
2. Аймгийн нийгэм эдийн засгийн танинцуулга 2009-2023
3. Дундговь аймгийн товч түүх 1991 он
5. www.nso.mn
6. www.1212.mn



ХЯНАСАН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА:

Б.ЭНХТУЯА

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН МЭРГЭЖИЛТЭН:

Н.ДАВААНЯМ

УТАС: 70593715, 88078816

И-МЭЙЛ: Dundgovi@nso.mn, davaanyam@nso.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛСЭС

2024 ОНЫ 5 САРЫН 30



Dundgovi@nso.mn



70593715